



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 09 өдөр Дугаар 22

Хэрлэн сум

ХХII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 22 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 08:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 87,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хуваарьт хязгаарлалт тогтоох эсэх талаар,

Цагдаагийн газар

2.Аймгийн Засаг даргын 2020 оны А/88 дугаар захирамжаар баталсан Коронавируст халдвар /COVID-19/-ын үед ажиллах мэргэжлийн багуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн дүгнэлт, мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат

3.Урлаг, соёлын арга хэмжээ, үзвэр үйлчилгээнд хязгаарлалт тогтоох эсэх талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

4."Монгол цэргийн өдөр"-ын арга хэмжээг аймгийн хэмжээнд тэмдэглэхгүй байх талаар шийдвэр гаргах,

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн

5.Хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа, иргэдийн хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгах эсэх талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

6.Хилийн Бичигт боомтоор тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавьж буй хяналтын талаар мэдээлэл танилцуулах,

Мэргэжлийн хяналтын газар, Автотээврийн газар

7.Ноолуур худалдан авах иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах талаар хэлэлцэх,

*АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс,
Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар*

М.Бадамсүрэн
Д.Баттулга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

1.1.Согтууруулах ундааны хэрэглээ, архидалттай холбоотой мэдээллийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дараагийн хуралд танилцуулахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.2.Согтууруулах ундаагаар үйлчилгээний эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт, шалгалтыг зохион байгуулж дүгнэлтийг аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Баяржаргал-д:



1.3.Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн санал, согтууруулах ундаатай холбоотой гарсан зөрчлүүдийг үндэслэн долоо хоног бүрийн Баасан гарагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргаж батлуулахыг,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн, хурандаа Б.Бямбаа,
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

2.1.Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб, тохиолдлын удирдлагын тогтолцооны багуудын бэлэн байдлыг хангуулах хамтарсан дадлага, сургуулийг аймгийн төвийн Хэрлэн сум болон хөдөөгийн нэг сумтай хамтран зохион байгуулахыг,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын
гишүүн Б.Ганганцэцэг нарт:

3.1."Зорчигч тээвэрлэлтийг зохицуулах түр журам"-ын төсөлд аймгийн Онцгой комиссын гишүүдийн саналыг тусгаж аймгийн Засаг даргын захирамжаар батлуулахыг,

/  / М.Бадамсүрэн
/  Д.Баттулга

Дөрөв.Автотээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр-д:

4.1.Хилийн Бичигт боомтоор ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгслийн хяналт, халдвар хамгааллын дэглэмийг чангатгах талаар Зам, тээврийн хөгжлийн яаманд албан бичгээр санал уламжлахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа-д:

4.2.Хилийн Бичигт боомтоор ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгслийн хяналтыг эрчимжүүлэх, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх талаар газрын тосны "Тосон-Уул" XXI талбай хариуцсан Улсын хяналтын байцаагч нарт чиглэл өгөхийг,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Аймгийн хэмжээнд урлаг, соёлын үзвэр үйлчилгээ, спортын уралдаан тэмцээнийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

5.2."Монгол цэргийн өдөр"-өөр хөшөөнд цэцэг өргөх, албан хаагч нарт шагнал гардуулах үйл ажиллагаанаас бусад арга хэмжээг нийтээр зохион байгуулахгүй байх, тухайн өдөр согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйлчилгээг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

5.3.Ноолуурын худалдан авалтыг зохицуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА